

**“Тотгорын зурхай дөчин долоон чулууны гарын авлагын
товч хураангуй болор толь” хэмээхэд хийсэн ажиглалт**

Дамдинсүрэнгийн ДАВААСҮРЭН*
Монгол улс, Улаанбаатар,
Соёл Урлагийн Их Сургууль,
Театр урлагийн сургууль

Received: Jun 11, 2024

Revised: Sep 21, 2024

Accepted: Oct 07, 2024

Хураангуй: Тус өгүүлэлд, Шива ширээтийн шавь Лувсандагдангийн бичсэн “Тотгорын зурхай дөчин долоон чулууны гарын авлагын товч хураангуй Болор толь”⁹⁰ хэмээх төвөд хэлээр бичсэн, гар бичмэл, 28 тал судрыг төвөд хэлнээс орчуулан, судалгааны эргэлтэд оруулсан болно.

Түлхүүр үг: төвөд хэлт утга зохиол, зурхайн эх сурвалжууд, тотгорын зурхай

**Observation on the Book “A Short Summary of Handbook of Forty-Seven
Stones of Totgor Astrology”**

DAVAASUREN Damdinsuren
School of Theater Arts
Mongolian National School of Arts and Culture
Ulaanbaatar, Mongolia

Abstract: This is a summary of the handbook of the forty-seven stones of Totgor astrology by Luvsandagdan, a disciple of Shiva Shirat. The book “Bolor toli” has a length of 14 and 28 pages and was written in 1905 according to our assumption. It consists of a devotional poem with the author’s oath, a final poem with information about the author and blessings, and has the following structure:

1. The twelve years (lines 2-4 of page 2a)
2. The five entities of wood, fire, earth, metal, and water (lines 4 of page 2a, lines 1-3 of page 2b)

* © Д.Даваасүрэн 2024

Email: davaasurend810@gmail.com

⁹⁰ тө. skeg rtsis rde’u zhe bdun ma’i lag len mdor bsdus shel gyi me long zhes by aba bzhugs so

3. *Recognizing life (lines 3-4 of page 2b)*
4. *Recognizing the body (lines 4-6 of page 2b)*
5. *Recognizing the organs (lines 1-3 of page 3a)*
6. *Recognizing the humors (lines 3-5 of page 3a)*
7. *Calculating the internal year or the return (lines 5 of page 3a, line 1 of page 3b)*
8. *The method of calculating the seats: calculating the internal seat from the three seats called external, internal, and secret (lines 1-3 of page 3b)*
9. *Calculating mole (from line 3 of page 3b, lines 1-5 of page 4a)*
10. *The year of falling on evil days (from line 5 of page 4a, line 1 of page 4b)*
11. *The secret of calculating mole (from line 1 of page 4b, lines 1-5 of page 5a)*
12. *Recognizing the amount of time (from line 5 of page 5a, lines 1-5 of page 5b)*
13. *The rule of calculating fate to prosper and degrading in life (from line 6 of page 5b, lines 1-2 of page 6a)*
14. *A guide to laying stones (from line 3 of page 6a, line 1 of page 8b)*
15. *Preach fortunes using stone calculations (from line 1 of page 8b, line 1 of page 14a)*

The poem of the sacrifice states, "... the horoscope of Mahbod, the horoscope of the Peak, and the horoscope of the Black are such numbers. The origin of the word is that it was pronounced by the soft vowel of the Utai five mountains. Some sages believe that it was composed by Chinese kings. In it, ... the horoscope, the horoscope of Totgor, the horoscope of "Ber", the horoscope of the Dead, the horoscope of the Earth, the horoscope of running and existence of the Earth owner, these are all seven collections.

It is said that the material world and a biosphere are all derived from the turtle, and some sages also said that it is difficult to be convinced of it" (lines 1.1b.2-4, lines 2a.1-2), and briefly notes of previous researches and the views of other people related to the main content of the book.

In this article, the following conclusions are drawn from the above 15 contents, "Calculating the Inner Year or the Ascendant" and "The Secret of Calculating the Moon":

1. "The year reached by counting down from the year of birth of a male and female is the year of the Ascendant, and the year reached by counting up from the year of birth of a female and male is the year of the Ascendant." This is the method of finding the Ascendant in the astrological reference book or textbook called phug lugs rtsis kyi legs bshad mkhas pa'I mgul rgyan beed'ur dkar po'I do shal dpyod ldan snying nor.

2. However, "it does not matter whether the person is male or female, it is found based on the male or female of the year of birth", and "depending on whether the person is male or female, the male is counted down from the year of the Ascendant,

which is the year of the Ascendant, the Ascendant of The custom of counting the years of a woman's birth by counting upwards from the year of her birth, which is the year of her birth, is condemned as "self-invented."

3. Luvsandagdan said, "Starting from the birth mole, count the years downwards, and wherever the number matches that age, it is probably the mole that fell." Taking the example of a person born in 1897 and 9 years old at the time of writing the book, who had a Wood Snake year and 4 green moles, the mole that fell in that year does not match the 7 red ones when calculating the moles in reverse.

4. However, when calculating the mole in a forward calculation, which says, "From the center, there is space, iron, mountain, fire, water, earth, wood, and temple," the mole that fell in that year, 9 years old in 1905, matches the 7 red ones.

Finally, Luvsandagdan's biography is still unknown. As far as is known, according to the three-page title of the complete works of Bogd Toyn Luvsandagdan, also known as Shandi, "Suvdan Erikh," a total of 89 works by him are listed by name. It also appears that there is a volume of secret status written before these, and another volume called "Erdeniyn Erikh", a record of Luvsandagdan's hearings, is separate. From this, it is reasonable to assume that Luvsandagdan wrote three volumes of works in Tibetan, including two works related to astrology: there is a Brief Summary of the Horoscope of the Dead, The "Bolor Toli", a comprehensive guide to astrology, and The Table of Contents, a summary of the Forty-Seven Stones of Totgor's Astrology.

Key words: Internal year, Year of rebirth, "Mole" calculation, "Totgor" astrology, Luvsandagdan, Sha Mesa Sodov, Mongolian studies, astrology

1. Удиртгал

Шива ширээтийн хүрээний аяга тахимлаг Лувсандагданы "Тотгорын зурхай дөчин долоон чулууны гарын авлагын товч хураангуй Болор толь" хэмээх ном нь дараах бүтэцтэй:

1. Арван хоёр жил хэмээх нь (2а талын 2-4 мөр)
2. Мод, гал, шороо, төмөр, ус тав нь (2а талын 4 мөрөөс, 2б талын 1-3 мөр)
3. Амийг танин барих (2б талын 3-4 мөр)
4. Биеийг танин барих (2б талын 4-6 мөр)
5. Эрхтнийг танин барих (3а талын 1-3 мөр)
6. Хийморийг танин барих (3а талын 3-5 мөр)
7. Дотоод жил буюу урвасныг тооцох (3а талын 5 мөрөөс, 3б талын 1 мөр)
8. Суудлыг тооцох ёс гадаад, дотоод, нууц гурваас дотоод суудал тооцох (3б талын 1-3 мөр)
9. Мэнгэ тооцох (3б талын 3 мөрөөс, 4а талын 1-5 мөр)
10. Мэнгэ голд орох жил (4а талын 5 мөрөөс, 4б талын 1 мөр)
11. Мэнгэ тооцох нууцын ёс (4б талын 1 мөрөөс, 5а талын 1-5 мөр)

12. Цагийн хэмжээг танин барих (5а талын 5 мөрөөс, 5б талын 1-5 мөр)
13. Өөдлөх, уруудах ямар мэтийг тооцох ёс (5б талын 6 мөрөөс, 6а талын 1-2 мөр)
14. Чулуу тавих гарын авлага (6а талын 3 мөрөөс, 8б талын 1 мөр)
15. Чулууны үрийг номлох (8б талын 1 мөрөөс, 14а талын 1 мөр)

Дээрх бүтэц, агуулга нь цахар гэвш Лувсанцүлтим, мөн төвөдийн зурхайч Лхамцүлтимийн эмхэтгэсэн “**nag rtsis rdel ‘grem ‘bras bzhad bzhugs so**” хэмээхийн бүтэц, агуулгатай ерөнхийдөө ижил байна.

Мөн бид 2010 онд, цахар гэвш Лувсанцүлтимийн “**sgeg rtsis rde’u zhe bdun ma’i lag len mdor bsdus zhel gyi me long zhes by aba bzhugs so**”-д тулгуурлан, нэгэн жилийн тотгорыг шинжлэх тооцох арга, аргачлалыг сурах бичгийн зориулалтаар боловсруулж, зурхай судлалд зориулсан цувралын гурав дахийг “**Увдисын утгын хураангуй**” нэрээр олны хүртээл болгосон.

Тиймээс энэхүү өгүүлэлдээ дээрх бүтэц, агуулга бүрээр биш, зөвхөн Лувсандагдан болон цахар гэвш Лувсанцүлтим нарын зөрөөтэй ойлголтуудыг дэлгэрүүлж, өөрсдийн чадахын хэрээр тайлбарлахыг хичээсэн болно.

Дээрх бүтэц, агуулгын жагсаалт дахь 1-6, 8-10, 12-15-д буй агуулгууд үндсэндээ зөрөөгүй байна. Тиймээс эдгээрийн талаар тухайлан авч үзэхгүй. Харин 7, 11 дэх агуулга зөрөөтэй байгаа тул эдгээрийг харьцуулан, тайлбарлах болно.

2. Судалгааны арга хэрэглэгдэхүүн

Бид тус судалгаандаа Шива ширээтийн хүрээний аяга тахимлаг Лувсандагданы “Тотгорын зурхай дөчин долоон чулууны гарын авлагын товч хураангуй Болор толь” зохиолд тулгуурлан, Цахар гэвш Лувсанцүлтимийн “Махбодын зурхайн ёсны жилийн тотгорыг шинжлэх увдисын утгын хураангуй оршвой” хэмээх төвөд модон барын судар, Сэрдог гэгээний туурвисан “Махбодын зурхай Эрдэнэ бүгдийн хураангуй” хэмээх богино цаастай төвөд гар бичмэл судрыг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон, эх хэрэглэгдэхүүнээ тулган харгуулах, задлан шинжлэх аргыг хэрэглэв.

3. Судалгааны хэсэг

Төгсгөлийн болон тахилын шүлэг, номын гол агуулгын тухай

Уг номын төгсгөлийн үг нь “энэ нь бандида богд Шива ширээтийн шавийн адаг, аяга тахимлаг Лувсандагдан бээр мэргэжсэн нүгүүдийн таалсанчлан нэгэн зүгт жигдэлсэн буян үүгээр амьтан бүхэн ойрын хөнөөлөөс гэтлээд, бүхнийг болгоогчийн хутаг түргэнээ олох болтугай. Өлзий хутаг болон сайн буян арвидагтун”⁹¹ (1.14а.1-4 мөр) гэсэн байна.

⁹¹ тө. zhes pa ‘di ni pantita rje btsun zhi ba shri’ ke thu’i, slob ma’i tha shal gyi na pa, dge slong blo bzang grags ldan gyis, mkhas pa rnam ky i bzhed pa bzhin, phyogs gcig bsgrigs pa’i dge ba ‘dis, ‘gro

Дээрх төгсгөлийн үг нь нэгд, зохиогчтой холбоотой мэдээлэл, хоёрт, ерөөлөөс бүрдэж байна.

Мөн “*төрсөн мэнгэ дөрвөн ногоон тахиа жилтэн ес хүрсэн хүний буусан мэнгэ нь модон могой жил үүнд долоон улаан мөн*”⁹² (1.5а. 2 мөр) гэснээс үзвэл, уг номыг аргын тооллын 1905 онд бичсэн байна. Зохиогчтой холбоотой дараах мэдээлэл бидэнд байна. Үүнд:

1. Зохиогчийн нэр: Лувсандагдан
2. Зохиогчийн харьяалал: Шива ширээтийн хүрээ

Ерөөл нь нэгд, Лувсандагдан нь уг номын гол агуулгаар мэргэшсэн бусад хүмүүсийн зохиолд үндэслэн найруулсан, хоёрт, “ойрын хөнөөлөөс” буюу амь нас, эрүүл мэнд, эд баялаг, ажил хөдөлмөрт тотгорлогч шалтаг шалтгаанаас гэтлээд, гэгээрэх болтугай хэмээсэн хоёр хэсэг агуулгаас бүрдэж байна.

Лувсандагданы найруулсан уг ном нь гар бичмэл бөгөөд нийт урт цаасны 14 хуудас, 28 тал болно.

1а талын голд номын нэр, цаасны дээд голд “Ум а хум, базар гүрү бадма сиди хум” гэх тарни бүхий дардас, номын нэрийн доод талд “Со” (zo) гэх үсэг бүхий жижиг дардсыг хоёр удаа дарсан байна. Бидэнд буй уг ном нь эхээс цахим машин ашиглаж дахин хувилсан хуулбар тул эхийг томруулсан эсэхийг тодорхой мэдэхгүй байна. Ямартай ч, цаасны хэмжээ нь 42х9.8 см байна. Цаасны дээд голд буй дардасны хэмжээ нь 8х1.5 см, номын нэрийн доод талд буй дардас нь 1.3х2 см байна. 1б, 2а тал нь гаднаа 37.8х7.8, дотроо 36.1х6.2 см давхар хүрээтэй, дотор хүрээний зүүн гар талаас 6.2 см, баруун гар талаас 6 см зай авч хайрцаг үүсгээд, 24х6.2 см бүхий зайд тус бүр 4 мөр, цаасны хоёр талаас 3.8 см зай авч 2б-13б тал хүртэл нийт 23 талд тус бүр 6 мөр, 14а талд 4 мөр үүсгэн, нийт 150 мөрд багтаан гараар бичжээ. Цаасны “а” талын баруун гар талын зайд хөндлөнгөөр “тотгорын зурхай” хэмээн номын гол агуулгыг тэмдэглээд, хуудсыг дугаарласан байна.

Тахилын шүлэг нь:

“Богд тойн багш Зөөлөн эгийгт

Ялгалгүйн өлмийд бишрэнгүйгээр сөгдөөд

Тотгорын зурхайн дөчин долоон чулууны

Гарын авлагыг товч төдий зохион үлдмүй”⁹³ (1.1б.1-2 мөр) гэснийг агуулгаар нь дараах хоёр хэсэгт хувааж болно. Үүнд:

1. Мөргөл
2. Зохиогчийн тангараг

kun nyer ‘tshe las grol nas, kun mkhyen go ‘phang myur thob shog. bkra shes pa dang dge legs ‘phel bar gyur cig

⁹² тө. skyes sme bzhi ljang bya lo pa, dgu lon mi yi bab sme ni, shing sbrul lo ‘dir bdun dmar yin

⁹³ тө. tje btsun bla ma ‘jam pa’i dbyangs, dbyer med zhabs la gus ‘dud nas, skeg rtsis rde’u zhe bdun ma’i, lag len mdo tsam ‘god par bya

Мөргөлийн утга нь Лувсандагдан өөрийн багшийг Зөөлөн эгшигт буюу Манзуширтэй нэг мөн чанартай хэмээгээд багшдаа мөргөсөн байна. Мөргөл нь “Долоон гишүүнт тахил”-ын хоёр дахь өөрийн омогт бардам сэтгэлийн ерөндөг бөгөөд бие, хэл, сэтгэлийн гэх гурван зүйлтэй. Эл хоёр мөрд багшийгаа Манзуширтэй ялгалгүй мөн чанартай хэмээн бясалгаж, бишрэнгүй сэтгэлээр мөргөсөн утгатай байна.

Төвөд хэлт зохиолуудын тахилын шүлэг нь одоогийн номын өмнөтгөл, өмнөх үгтэй хэрэг үүргийн хувьд ижил төстэй юм.

Тахилын шүлэгт залгуулан

“тэр ч Махбодын зурхай, Оргил талын зурхай, Хар зурхай нугууд нь тийн тоо мөн. Уг гарвал нь Зөөлөн эгшигт бээр Утай таван ууланд зарлигласан хэмээн номлосон. Зарим мэргэд бээр Хятадын хаад бээр туурвисанд таалдаг. Тэрэнд ч ... зурхай, Тоггорын зурхай, Бэрийн зурхай, Үхэгсдийн зурхай, Газрын шинжээ, Газрын эзний орших, гүйхийн зурхай зэрэг бүдүүн төдий хурааваас долоо. Сав, шим нүгүүд яст мэлхийгээс гарсанд номлосон бөгөөд зарим мэргэд сэтгэл бататгахад бэрх хэмээн номлосон нь ч буй”⁹⁴ (1.16.2-4 мөр, 2а.1-2 мөр)

гэх өмнөх судлагдсан байдал, уг номын гол агуулгад холбогдох бусад хүмүүсийн үзэл тайлбарыг товч сийрүүлэн тэмдэглэжээ.

Лувсандагданы дээрх тэмдэглэлд буй “Зарим мэргэд бээр хятадын хаад бээр туурвисанд таалдаг” гэсэн нь “махбодын зурхай”, “оргил талын зурхай”, “хар зурхай”-н алинд хамаарах нь тодорхойгүй байна. Гэвч, бидэнд буй бусад эх сурвалжаас үзвэл зөвхөн хар зурхайд холбогдох нь тодорхой байна. Учир нь “...хар зурхайн гарал үүсэл нь Хятадын хаан, мэргэн оюунтнууд үйлдсэн болой. Тэр ч урьдын цагт хятадын оронд “гурван Хун”, “таван Ди” хэмээх найман хаан дараалан хаан төрийг тэтгэсний анхдугаар Хун Түй Хоу Пү Шри хэмээх хаан хятадын хэлэнд Ба-га хэмээх эдүгээ төвөдийн хэлэнд Барха хэмээн алдаршсаны найман шинж үүнийг туурвисан. Бас энэ хаан бээр Цүн-жэ хэмээх түшмэлд тушаан хятад үсэг шинээр урлуулснаас дараалан хятад үсэг дэлгэрсэн байна. Хоёрдугаар Хун хаан өвчнийг анагаах эмийн аймаг судсанд шинжлээд өвчнийг мэдэх арга, таван махбодын дэлгэрэх доройтох тэргүүтнийг нягтлаад олон бичиг туурвисан. Эдүгээ Төвөдөд дэлгэрсэн эмийн бичиг ихэнх зонхийн үндэс нь Хятадаас гарсан мөн болно. Түүний хойно гуравдугаар Хун хаан таван махбодыг эр, эм хоёрт ялган “Арван үндэс” хэмээсэн болон хулгана, үхэр

⁹⁴ тө. de yang ‘byung rtsis spr thang rtsis, nag rtsis rnams ni nram grangs yin, byung ba’i khungs ni ‘jam dbyangs kyis, rib o rtse lngar gsungs zhes bshad, mkhas pa ‘ga’ yis rgya nag gi, rgyal po rnams kyis brtsams par bzhed, de la’ang gtan rtsis skeg rtsis dang, bag rtsis gshin rtsis nad gdon rtsis, sa dpyad sa bdag gnas rgyu ba’i, rtsis te rags tsam bsdu nab dun, snod bcud rnams ni rus sbal las, byung bar bshad cing mkhas pa ‘gas, yid brtan dka’ zhes bshad pa’ang yod.

*тэргүүтэн арван хоёр нэрээр жил, сар, хоног, цаг нугуудыг тооцох журмыг тавьсан*⁹⁵ (2.1б. 3-5 мөр. 2а. 1-5 мөр)

хэмээн Цахар гэвш Лувсанцүлтим дэлгэрэнгүй тэмдэглэсэн байдаг.

Бас Лувсандагданы тэмдэглэснээр “*сав, шим нүгүүд яст мэлхийгээс гарсанд номлосон*” гэдэг нь үнэмшихэд бэрх хэмээжээ. Үүнтэй маргалдах, ямар нэг байдлаар үгүйсгэх гэх нь эдүгээ огт хэрэггүй. Ер нь тэгж үзэх, сав шим ертөнцийн зүй тогтлыг ойлгуулахад хамгийн хялбар нь энэ үлгэр ч байсан байж болох юм. Бидэнд “*gtso mo'i gser mdog mkham pa khyung gi mdzad pa bzhugs so*”, “*sgeg rtsis rde'u zhe bdun ma'i lag len mdor bsdus zhel gyi me long zhes by aba bzhugs so*” гэх зохиолыг залгуулан, хуулан бичсэн богино цаастай нэгэн төвөд гар бичмэл байна. Эхнийх нь Сэрдог гэгээний “**Махбодын зурхай Эрдэнэ бүгдийн хураангуй**” хэмээх бөгөөд удаах нь Цахар гэвшийнх болно. Сэрдог гэгээн бээр:

*“Ертөнцөд үзүүлсэн хүрдэн үүний
Үндэс их яст мэлхий учраас
Тэр ч гэдрэгээ харан байгаагийн
Толгой урагшаа харж, сүүл хойшоо
Баруун уушги зүүнд, зүүн уушги баруун
Гишүүн дөрвөн завсарт жийн орижээ.
Тэндээс суудал, мэнгэ, жил зэрэг
Номлосныг дараалан үзүүлэх нь
Зүүн зүг модонд, урд зүг гал
Баруун зүг төмөрт, умар зүг ус
Завсрын дөрөв шороонд мэдэж үйлд”*⁹⁶ (3.1б. 2-6 мөр)

хэмээгээд энэ найман суудлыг тооцох ёсны үндэс болж, улмаар найман зүг, арван хоёр жил тэргүүтний амин махбодыг тооцох ёсыг үүнд үндэслэн боловсруулсан байна. Энэ нь Цахар гэвш Лувсанцүлтимийн “*анхдугаар Хун Түй Хоу Пү Шри хэмээх хаан хятадын хэлэнд Ба-га хэмээх эдүгээ төвөдийн хэлэнд Барха хэмээн алдаршсаны найман шинж үүнийг туурвисан*” хэмээсэнд

⁹⁵ тө. nag rtsis thog mar 'byung ba'i khungs ni, rgya nag gi rgyal po mkhas pa blo ldan dag gi bya'o, de yang sngon gyi dus su rgya nag gi yul du hung gsum d'i lnga shes pa'i rgyal po brgyad rim par srid bskyangs pa'i hang dang po thu'i ho'u ph'u shr'i zhi zhes pa'i rgyal pos rgya nag gi skad du pa' ka' zhes pa da lta bod du spar kha zhes grags pa'i rtags brgyad 'di brtsams so. yang rgyal po 'dis tshung kye zhes pa'i blon po la gtad nas rgya nag g i yi ge gsar du bzos pa las rim gyis rgya yig dar ro. rgyal po hung gnyis pas, nad gso pa'i sman gyi skor rtsal brtags nas nad shes thabs 'byung ba lnga'i dar rgud sogs gtan la 'bebs pa'i ye gem ang tu brtsams so. deng sang bod tu dar ba'i sman yig phal cher gyi rtsa b ani rgya nag nas byung ba yin par 'dug go. de rjes rgyal po hung gsum pas 'byung ba lnga pho mo gnyis su phye ba rtsa ba bcu shes pa dang, byi glang sogs ming bcu gnyis kyis lo zla zhang dus nams brtsis ba'i srol btong

⁹⁶ тө. 'jig rten bstan pa'i gtsug lag 'di, rtsa ba'i rus spal chen po te, de yang gan rkyal dag du gnas, mgo po lhor bstan mjug ma byang, glo gyas shar la glo gyon nub, yan lag mtshams bzahir rkyang nas gnas, de las spar sme lo 'gros sogs, chad pa'i rim pa bstan pa ni, shar phyogs shing la lho phyogs me, nub phyogs lcags la byang phyogs chu, mtshams bzhi sa r ushes par bya

холбогдоно. Эндээс “сав, шим нүүгүүд яст мэлхийгээс гарсанд номлосон” гэдгээс машид нарийн, гүн гүнзгий ойлголтыг олон нийтэд ойлгуулах, түүгээр дамжуулан нийгмийн амьдралд эв зохицол, хүмүүн болон байгаль, хүн болон хүний харилцааны хэм хэмжээг тогтоох санаагаар аливааг үлгэрээр үзүүлэх нь хялбар байдагтай холбон ойлгосон ч буруудаад шалихгүй болов уу гэж санагдана.

4. Судалгааны үр дүн

Дотоод жил буюу урвасан жилийг тооцох

“Дотоод жил”⁹⁷, “Урвасан жил”⁹⁸ гэх нь ижил утгатай. Ер нь үүнийг тооцох харилцан адилгүй 3 арга эдүгээ хэрэглэдэг. Лувсандагдан нь эдүгээ нийтлэг барьдаг ёсыг “тооцох ёс энэ ямагт Бидэргарав тэргүүтэн гол номлол нугуудын таалал”⁹⁹ (1.3б.1 мөр) хэмээн зөвшөөгөөд, бусад аргыг “зарим нэгэн үүнтэй таарахгүйгээр тооцдог, тэр нь өөрөө урласан болой”¹⁰⁰ (1.3б. 1 мөр) гэсэн нь анхаарал татаж байгаа юм.

“phug lugs rtsis kyi legs bshad mkhas pa'i mgul rgyan beed'ur dkar po'i do shal dpyod ldan snying nor” буюу товч нэр нь “Бидэргарав” тэргүүтэй гол номлолд буй, эдүгээ нийтлэг хэрэглэдэг арга нь “эрэгтэй хүн мөн бөгөөс төрсөн жилийн эрхтний хүү бараас нас тоолон уруудуулан тоолох хийгээд эмэгтэй хүн мөн бөгөөс төрсөн жилийн эрхтний эх бичээс нас тоолон өгсүүлэн тоолсноор аль хүрсэн жил тэр урвасан жил мөн”¹⁰¹ (1.3а.5-6 мөр) гэх энэ юм.

Лувсандагданы “өөрөө урласан” хэмээн буруушаасанд хамаарах бусад аргын талаар бид “Увдисын утгын хураангуй” цувралд авч үзсэн. Тодруулбал, “тухайн хүн эр, эм аль болох нь хамаагүй, төрсөн жилийн эр, эмээс шалтгаалан олдог нэг ёс” (4.66 тал. Хүснэгт 1 үз), “хүний эр, эм алин болохоос шалтгаалан эрэгтэй нь төрсөн жилийн эрхтэн махбодын хүү болох эрхтэн махбодын жилээс доош уруудуулна. Эмэгтэй нь төрсөн жилийн эрхтэн махбодын эх болох эрхтэн махбод бүхий жилээс дээш өгсүүлэн насны тоогоор тоолдог ажээ” (4.67 тал. Хүснэгт 2 үз).

Хүснэгт 1. Урвасан жил олох бусад арга-1

(Төрсөн жил нь эр хүмүүсийн жишээн дээр)

Махбод	Мод	Гал	Шороо	Төмөр	Ус	Эхлэн тооцох жил
Төрсөн жил	хулгана	бар	луу	морь	бич	Хүү бараас

⁹⁷ тө. nang lo

⁹⁸ тө. log min

⁹⁹ тө. brtsi tshul 'di nyid bee dkar sogs, gzhang chen mams kyi dgongs pa ste

¹⁰⁰ тө. kha cig 'di dang mi mthun par, brtsis pa de ni rang bzo'o

¹⁰¹ тө. mi pho yin na skyes lo yi, dbang than gi nib u stag nas, lo grangs thur du bgrang ba dang, mi mo yin na skyes lo yi, dbang thang gi ni ma sprel nas, lo grangs gyen du bgrang bay is, gang sleb lo de log min yin

Төрсөн жил	нохой	хулгана	бар	луу	морь	Хүү хулганаас
Төрсөн жил	бич	нохой	хулгана	бар	луу	Хүү нохойноос
Төрсөн жил	морь	бич	нохой	хулгана	бар	Хүү бичээс
Төрсөн жил	луу	морь	бич	нохой	хулгана	Хүү мориос
Төрсөн жил	бар	луу	морь	бич	нохой	Хүү луунаас

Хүснэгт 2. Урвасан жил олох бусад арга-2

(Л.Тэрбишийн баримталдаг арга)

Эр	бар	тахиа	морь	могой	бич	үхэр	луу	тахиа	хулгана	могой	бич	туулай
Төрсөн жил	хулгана	үхэр	бар	туулай	луу	могой	морь	хонь	бич	тахиа	нохой	гахай
Эм	бич	Могой	хулгана	гахай	морь	туулай	бар	могой	нохой	хонь	морь	тахиа

Товчдоо, Лувсандагдан нь дээр “Увдисын утгын хураангуй” зурхай судлалын “Цуврал III”-аас тодруулсан урвасан жил олох бусад арга нь зурхайн гол тулгуур сурвалж буюу сурах бичиг болох “Бидэргарав”-ын ёс биш гэж үзсэн байна.

Мэнгэ тооцох арга

Ер нь “Бидэргарав”-д мэнгэний талаар “Мэнгэний эрхэс” хэмээх дотроо гурван зүйл ухагдахууныг номлосон болохыг тэмдэглээд, улмаар дараах дэд зүйлсийг тодруулан тайлбарласан байна. Үүнд:

1. Мэнгэ голд орох жил¹⁰²

2. Төрсөн мэнгэ хайх ёс¹⁰³

3. Нууцын тооцох ёс¹⁰⁴-ыг тус тус тодруулан тэмдэглэсний 1, 2 нь нийтийн буюу эдүгээ баримталж буй тооцох аргатай таарч байна. Тиймээс “мэнгэ тооцох арга” гэх энэ хэсэгт зөвхөн 3 дахь буюу “Нууцын тооцох ёс”-ны талаарх тэмдэглэлийг тухайлан авч үзье. Лувсандагдан

¹⁰² тө. sme ba dbus su 'jug lo

¹⁰³ тө. skyes sme 'tshol tshul

¹⁰⁴ тө. gsang ba'i rtsis tshul

“төрсөн мэргийг голд тавиад зүүн рүү гаран эргүүлэх ёсыг жилийн эр эмээр бөлгөө. Эр жилтэн зүүн эргэснээр зүүн урд завсраас төвд ирнэ. Эм жилтэн баруун эргэснээр зүүн хойд завсраас төвд ирнэ. Арван бүхэл нэжгээдэд мэнгэ нэжгээд, үлдсэний тоонд ч нэжгээд нэжгээд татна. Үлгэрлэвээс төрсөн мэнгэ нэг мөн аваас нас арав хүрэхийн цагт нэгэн цагаанд, хорь хүрэхийн цагт хоёр хард, хорин нэг хүрэхийн цагт гурван хөх, хорин ес хүрэхийн цагт хоёр хард буух мөн болой бусад нугуудыг жиш. Товчилбоос, төрсөн мэнгэнээс эхлээд доош нас тоолонгоор хөөгөөд тоо тэр нас хаана таарсан тэр нь буусан мэнгэ магад мөн. Өнөө маргаашийн олон зурхайч буусан мэргийг үсэргэн тооцож байна. Төрсөн мэргийг төвд тавиад хэмээн номлосон тул төрсөн мэнгэ тооцох ёс биш нь тодорхой. “Эргүүлэх ёс” хэмээх тэргүүтэн номлосон тул “үсэргэн” тооцох таарахгүй. “Арван бүхэл нэжгээдэд” хэмээх тэргүүтэн зарлигласан. Тийм тул нас тоолон тооцох хэрэгтэй. Та нарын тооцох ёс мэт аваас төрсөн мэнгэ дөрвөн ногоон тахиа жилтэн ес хүрсэн хүний буусан мэнгэ нь модон могой жил үүнд долоон улаан мөн. Тиймээс тэр хүн арав хүрэх цагт буусан мэнгэ дөрвөн ногоон мөн үү биш үү, мөн аваас толгойд эсэргүүцэл бууж галт барс дүүлсэн адил болно. Биш аваас арав хүрэхийн цагт мэнгэ голд орохгүй юм уу, мэнгэ төвд орох төрсөн мэнгэний дээр буух бус уу хэмээн аль мөнийг өгүүлэх вэ. Тиймийн тул чиний тооцох ёс тэр машид зохисгүй, инээдэм наадмын орон. Ухаан төгс нугууд сайтар шинжлээд алсарч орхилгүй үйлдвээс сайн”¹⁰⁵ (1.4б. 1 мөрөөс, 5а. 1-5 мөр)

ГЭЖЭЭ.

Мэнгэтэй холбоотой тооцоолуурт “үсэргэн тооцох”, “эргүүлэн тооцох” гэх хоёр арга байгаа нь дээрх эшлэлээс тодорхой байна. Үүнээс “Бидэргарав”-аас эргүүлэн тооцохын утгыг тодруулбал “эргүүлэх ёс төвөөс зүүнд гарна. Бодгаль эр, эм ямар мэт болно. Эр жил төвөөс зүүн гарах буюу зүүн хойд завсарт хүрээд, зүүн урдаас төвд одох болой, эм жил нь төвөөс зүүн гаран,

¹⁰⁵ тө. skyes sme dbus bzhas shar du thon, bskor lugs lo yi pho mo ste, pho lo pa la gyon bkor gyis, shar lho'i mtshams nas dbus su 'ong, mo lo pa la gyas bskor gyis, byang shar mtshams nas dbus su 'ong, bcu tshan re la sme ba re, lhag ma'i grangs kyang re re 'dren, dper na skyes sme gcig yin na, lo bcu lon tshe gcig dkar la, nyi shul on tshe gnyis nag la, nyer gcig lon tshe gsum mthing la, nyer dgu lon tshe gnyis nag la, bab pa yin no gzhan rnams 'gre, mdor na skyes sme nas bzung ste, mar la 'ded nas lo grans kyis, bgrang ba de tshe gang bab pa, de ni bab sme yin par nges, deng sang rtsis mkhan mang po yis, bab sme 'phur nas brtsis 'dug ste, skyes sme dbus bzhas ces bzhas pas, skyes sme 'tshol tshul min par gsal, bskor lugs zhes sogs gsungs pas na, 'phur nas brtsis pa mi 'thad do. bcu tshan re la zhes sogs gsungs, de phyir lo grangs brtsi ba dgos, khyod rnams brtsis pa'i lugs ltar na, skyes sme bzhi ljang bya lo pa, dgu lon mi yi bab sme ni, shing sbrul lo 'dir bdun dmar yin, des na mi de bcu lon tshe, bab sme bzhi ljang yin nam min, yin na thod brgal gyis bab pa, me stag 'phros pa lta bur gyur, min na lo bcu lon pa'i tshe, sme bad bus 'jug ma yin nam, sme bad bus 'jug skyes sme'i steng, bab min zer ba gang yin smros. de phyir khyod kyi brtsi lugs de, shin tu mi rigs bzhas gad gnas, blo ldan rnams kyis legs dbyad nas rin du dor bar byed na legs

зүүн урдад одоод, зүүн хойноос дотогш орж үйлдү”¹⁰⁶ (5.260) гэсэн бол, үсэргэн тооцохын утгыг “өөр өөрийн төрсөн мэргийг төвд агуулаад наймаар эргүүлсний наян нэг төвөөс огторгуй, төмөр, уул болон гал, ус, мод, хий нугуудад оршино”¹⁰⁷ (5.260) гэсэн нь мөн. Үүнийг Лувсандагдан “Өнөө маргаашийн олон зурхайч буусан мэргийг үсэргэн тооцож байна. Төрсөн мэргийг төвд тавиад хэмээн номлосон тул төрсөн мэргэ тооцох ёс биш нь тодорхой. “Эргүүлэх ёс” хэмээх тэргүүтэн номлосон тул “үсэргэн” тооцох таарахгүй”¹⁰⁸ гэсэн нь бидний анхаарлыг татаж байгаа юм.

Цахар гэвш Лувсанцүлтим “Мэргэ тооцох арга”-ыг дараах таван зүйлээр үзүүлсэн байна. Үүнд:

1. Мэргэний махбод¹⁰⁹
2. Мэргэний орших ёс¹¹⁰
3. Мэргэ тооцох ёс¹¹¹
4. Сайн, мууг шинжлэх¹¹²
5. Ялгалыг шинжлэх¹¹³

Эдгээрээс Лувсандагдан 1, 2-ыг тухайлан гаргасангүй. “Есөн мэргийг таван махбодоор мөн амилуулдаг. Есөн мэргийг өнгөөр ялган дууддаг нь ийм учиртай юм. 1 цагаан, 6 цагаан, 8 цагаан гэдэг нь төмөр махбодтой. Төмрийг илэрхийлдэг өнгө нь цагаан. 2 хар, 3 хөх нь усан махбодтой. Усыг илэрхийлдэг өнгө нь хар юм уу, эсвэл хөх. 4 ногоон нь модон махбодтой. Модыг илэрхийлдэг өнгө нь ногоон. 5 шар нь шороон махбодтой. Шороог илэрхийлдэг өнгө нь шар. 7 улаан, 9 улаан нь гал махбодтой. Галыг илэрхийлдэг өнгө нь улаан” (4.79) юм. Цахар гэвш Лувсанцүлтим мэргэний орших ёсыг “төвөөс огторгуй, төмөр, уул хийгээд гал, ус, шороо, мод, хийд оршино хэмээсний дараалал мэт орших болой”¹¹⁴ (2.186. 1-2 мөр) хэмээсэн нь “Бидэргарав” дахь үсэргэн тооцох аргатай ижил бөгөөд үүнийг зургаар үзүүлсэн байдаг. Бид “Увдисын утгын хураангуй” цувралын 83 талд 35а, б, в, г, д, е, ё, ж, з хүснэгтээр үзүүлэн тайлбарласнаас дэлгэрүүлж үзнэ үү.

¹⁰⁶ тө. skor lugs dbus nas shar du thon, gang zag pho mo ji ltar rung, lo pho dbus nas shar thon te, byang shar mtshams phyin shar lho nas, dbus su ‘gro’o mo lo ni, dbus nas shar thon shar lhor ‘gro, byang shar nang du ‘jug par bya

¹⁰⁷ тө. rang rang skyes sme dbus bzhas la, brgyad kyis bskor ba’i brgyad cu gcig, dbus nas gnam lcags rib o dang, me chu shing rlung rnams gnas

¹⁰⁸ тө. deng sang rtsis mkhan mang po yis, bab sme ‘phur nas brtsis ‘dug ste, skyes sme dbus bzhas ces bzhas pas, skyes sme ‘tshol tshul min par gsal, bskor lugs zhes sogs gsungs pas na, ‘phur nas brtsis pa mi ‘thad do

¹⁰⁹ тө. sme kham

¹¹⁰ тө. sme ba’i gnas tshul

¹¹¹ тө. sme rtsis tshul

¹¹² тө. bzang ngan brtag pa

¹¹³ тө. bye brag brtag pa

¹¹⁴ тө. dbus nas gnam lcags rib o dang, me chu sa shing rlung la gnas, zhes pa’i rim pa ltar gnas pa’o

Тухайн хүний төрсөн мэргийг олохын тулд эхлээд насыг нь олно. Ингэхдээ “бодгаль эр, эм алин боловч эр жилтэнд төвөөс зүүн тийш гар. Зүүн эргүүлээд, зүүн урдаас төвд оруул. Эм жилтэнд төвөөс зүүн тийш гар. Баруун эргүүлээд, зүүн хойд завсраас төвд оруул” (4.79) гэх буюу “**Бидэргарав**” дахь эргүүлэх аргачлалыг ашигладаг.

Лувсандагданы “*төрсөн мэнгэ дөрвөн ногоон тахиа жилтэн ес хүрсэн хүний буусан мэнгэ нь модон могой жил үүнд долоон улаан мөн*” гэх жишээгээр бодоход, энэ нь 1897 онд төрсөн гал тахиа жилтэй, мэнгэний анхдугаар эрхсээр бол 4 ногоон мэнгэтэй хүн байна. Энэ хүнийг 9 нас хүрсэн модон могой жил бол аргын тооллын 1905 он болно. Модон могой жил нь 5 шар мэнгэтэй. Дээрх гал тахиа жилтний төрсөн мэргийг тодорхой мэдэхгүй гэх нөхцөлөөс дээрх анхаарал татаж байгаагийн учрыг тайлбарлах гэж хичээе. Ийм тохиолдолд, уг хүний хүйс эр, эмийн аль болох нь огт хамаагүй. Төвд 1, зүүн тийш гараад модонд 2, тахиа эм жил учир баруун эргээд ууланд 3, усанд 4, огторгуйд 5, төмөрт 6, шороонд 7, галд 8, хийд 9 таарна. Дараа нь огторгуйн жилийн мэнгэ 5 шарыг голд оруулаад, түрүүний нас хөөж тоолсон дагуу тоолбол, 9 насан дээр буюу хий суудал дээр 4 ногоон таарна. Энэ нь түүний төрсөн мэнгэ болно. Өөрөөр хэлбэл, төрсөн мэргийг олоходоо “*эргүүлэх ёс*” гэх аргачлалыг ашиглана. Лувсандагдан энэхүү “*эргүүлэх ёс*”-оор буусан мэргийг олно гэсний улмаас ойлголтын, бас хэрэглээний зөрүү гарч ирж байна. Жишээнд авсан 4 ногоон мэнгэтэй, 9 настай, гал тахиа жилтний буусан мэргийг олохын тулд 4 ногоон мэргийг голд оруулаад, эдүгээ нийтлэг хэрэглэдэг аргачлалаар бол мэнгэ үсэргэнэ. Тодруулбал, цахар гэвш Лувсанцүлтимийн “мэнгэний орших ёс” гэх аргачлалаар олно (Зураг 1 үз).

Гал тахиа жилтэй, 9 настай хүний төрсөн жил тахиа нь эм жил учир “*эм жилтэн баруун эргэснээр зүүн хойд завсраас төвд ирнэ*”¹¹⁵ гэсний дагуу 9 хүртэл төвд 1, модонд 2, хийд 3 гэх зэргээр нар зөв тоолоход ууланд 9 таарна (зураг 1 үз).

3	4	5
2	1	6
9	8	7

Зураг 1. *Есөн настны насыг олсон нь*

1905 оны огторгуйн жил нь модон могой бөгөөд 5 шар мэнгэтэй. Тиймээс “Зураг 1”-д насыг олсон дагуу огторгуйн жилийн 5 шар мэргийг төвд оруулаад, доош нас тоолон хөөвөл дараах болно (Зураг 2)

7	8	9
6	5	1
4	3	2

Зураг 2. *Есөн настны төрсөн мэргийг олсон нь*

¹¹⁵ тө. мо lo pa la gyas bskor gyis, byang shar mtshams nas dbus su 'ong

1897 онд төрсөн гал тахиа жилтний төрсөн мэнгэ нь 4 ногоон болох нь “Зураг 2”-оос тодорхой боллоо. Ерөнхийдөө энэ хүртэл тооцох ёсонд зөрөөгүй байна. Гэвч, Лувсандагдан нь “төрсөн мэнгэ дөрвөн ногоон тахиа жилтэн ес хүрсэн хүний буусан мэнгэ нь модон могой жил үүнд долоон улаан мөн”¹¹⁶ гэсэн нь “төрсөн мэнгэнээс эхлээд доош нас тоолонгоор хөөгөөд тоо тэр нас хаана таарсан тэр нь буусан мэнгэ магад мөн”¹¹⁷ гэдгээр бол 3 хөх таарахаас бус, 7 улаан таарахгүй (Зураг 3).

6	7	8
5	4	9
3	2	1

Зураг 3. Лувсандагданыхаар есөн настны буусан мэнгэ олох нь

Харин төрсөн мэнгийг голд оруулаад “төвөөс огторгуй, төмөр, уул хийгээд гал, ус, шороо, мод, хийд оришино хэмээсний дараалал мэт орших болой”¹¹⁸ гэх цахар гэвш Лувсанцүлтимийн мэнгэ орших ёс, эдүгээ нийтээр буусан мэнгэ олж буй аргаар мэнгэ үсэргэвэл 7 улаан таарч байна (Зураг 4).

	4	6
7		5

Зураг 4. Үсэргэн тооцох аргаар 1897 оны тахиа жилтний буусан мэнгэ нь

Энэ мэтээр өдгөө нийтлэг баримталдаг ёс, мөн өөрийнх нь авсан 1897 оны гал тахиа жилтний буусан мэнгэ 7 улаан гэдгийг тооцож буй ёсоор нь тус тус таарахгүй байгаагаас Лувсандагдан нь буусан мэнгэ олох аргыг эндүүрсэн шиг санагдана. “Бидэргарав”-д

“өөрийн мэнгийг төвд оруулж, эр баруун, эм зүүн эргэх гадаад, дотоод эргэх эрэгтэйн төрсөн мэнгэ, нялхсын бие, дээдсийн хийморь, эмэгтэйн эрхтэн, аль мөнхийг төвд оруулан эргүүлэн буусан болон өөрийн мэнгэтэй хэрэлдүүлэн үрд үзүүлэх, завсар юм уу, нууцын болон огторгуйн мэнгэтэй учруулан үрд үзүүлэх тэргүүтэн эндүүрсэн ёс олон боловч, хятадын цааз Эрдэнэ овоолсон тэргүүтэн хэмжил төгсөөс дамжсанаас тодорхой зарлигласан тул хорих бөгөөд тэвчихийн оронд үйлд”¹¹⁹ (5.260)

гэсэн байна. Цахар гэвш Лувсанцүлтим мэнгэний ялгалыг хэрхэн шинжлэхийг үзүүлэх үестээ “биеийн мэнгэ нь төрсөн жилийн амь, бие тэргүүтэн лүгээ учруулбаас гүрэм засал үйлдэх ёс гадаад жилийн үест номлосонд жишээрэй”

¹¹⁶ тө. skyes sme bzhi ljang bya lo pa, dgu lon mi yi bab sme ni, shing sbrul lo ‘dir bdun dmar yin

¹¹⁷ тө. mdor na skyes sme nas bzung ste, mar la ‘ded nas lo grans kyis, bgrang ba de tshe gang bab pa, de ni bab sme yin

¹¹⁸ тө. dbus nas gnam lcags ri bo dang, me chu sa shing rlung la gnas, zhes pa’i rim pa ltar gnas pa’o

¹¹⁹ тө. rang sme dbus bcug pa’i, pho gyas mog yon bskor ba phyi, nang skor skyes srog byis pa lus, yar abs klung rta bud med dbang, gang yin dbus bcug skor babs dang, rang sme ‘thabs pa’i ‘bras sus ton, bar ram gsang ba khug pa dang, gnam sme sprad pa’i ‘bras ston sogs, ‘khrul pa’i lugs kha du yod kyang, rgya them rin chen spungs pa sogs, tshad ldan rgyud nas gsal gsungs pas, dgag cing spang ba’i gnas su bya

гэсэн байдаг ч, хүмүүний эр, эм болон нас, алба тушаал тэргүүтнээр ялган үрийг шинжлэх талаар тэмдэглэсэнгүй. Харин

*“есөн наснаас дооших нялхсын хар мэнгэ нь 1 цагаан мөн. 18 хүртэлхийн хар мэнгэ 3 хөх мөн. 19-өөс дээш эрэгтэй хүмүүний хар мэнгэ нь 2 хар мөн болой. Тэр мэтчилэн бэлэвсэн эмэгтэйнх 4 ногоон, тойн хуврагийнх 5 шар, бөөгийнх 6 цагаан, эмэгтэйнх 7 улаан, ноён түшмэлийнх 8 цагаан, өвөг эмгэдийн хар мэнгэ нь 9 улаан болой”*¹²⁰ (2.34б. 8 мөрөөс, 35а. 1-4 мөр),

*эр жилтэнд дөрвөн зүгийн мэнгэнд буух болон эм жилтэнд дөрвөн завсрын мэнгэ бууваас ширүүн тоггор буй”*¹²¹ (2.36б. 1-2 мөр)

хэмээсэн байна. Энэ дашрамд сийрүүлэхэд, дөчин долоон чулууг “эрэгтэйд амь эрхэм, нялхаст бие, эмэгтэйд эрхтэн, хувраг болон ихэс дээдэст хийморь эрхэм болой”¹²² (2.18а. 2-3 мөр) хэмээн үрийг шинжилдэг. Эндээс нягталбал, “Бидэргарав” болон Цахар гэвш Лувсанцүлтим мэнгэний ялгалыг хэрхэн шинжлэх хоёр нь харилцан адилгүй ангид ойлголт байна. Өөрөөр хэлбэл, дөчин долоон чулуу тавих ёсонд буусан мэнгийг төрсөн жилийн амь, бие, эрхтэн, хийморь, сүлд лүгээ хэрэлдүүлж буй нь тухайлбал эрэгтэйн төрсөн мэнгийг буусан болон өөрийн мэнгэтэй хэрэлдүүлж байгаа явдал огт биш юм.

Мэнгэ тооцох гадаад, дотоод, нууц гэх гурван арга байдаг талаар “тооцох ёсонд гадаад, дотоод, нууц гурваас нууц нь төрсөн жилийн мэнгийг голд оруулан тооцно”¹²³ (2.32а. 1-2 мөр), өмнө өмнөх эрдэмтэд бүгд “ер нь мэнгэнд биеийн мэнгэ хийгээд тооцох ёсонд нууц гол”¹²⁴ (2.32б. 1 мөр) гэх мэтээр тодорхой тэмдэглэжээ. Эдгээрийн “бэлгэ чанарыг онолгүйгээр зүгийн унал буруу мэтэд унах нь олон” байдаг байна.

5. Дүгнэлт

Лувсандагданы энэхүү “sgeg rtsis rde’u zhe bdun ma’i lag len mdor bsdus zhel gyi me long zhes by aba bzhugs so” нь зурхай судлал, нэн ялангуяа Монгол газар дэлгэрсэн махбодын зурхайн сонирхолтой судлагдахуун мөн бөгөөд энэхүү номын агуулга дахь “Дотоод жил буюу урвасныг тооцох”, “Мэнгэ тооцох нууцын ёс” гэх хоёр хэсэгт ажиглалт хийснээр дараах дүгнэлтэд хүрч байна.

¹²⁰ тө. lo dgu man gyi byi ba’i sme nag ni gcig dkar yin, lo bco brgyad bar gyi khye’u yi sme nag ni gsum mthing yin, bcu dgu yan gyi mi pho’i sme nag ni gnyis nag yin no, de bzhin du yugs mo’i bzhi ljang, rab byung gi lnga ser, bon bo’i drug dkar, bud med kyi bdun dmar, rje dpon gyi brgyad dkar, rkan rkon gyi sme nag ni dgu dmar ro

¹²¹ тө. pho lo ba la phyogs bzhi’i smer babs pa dang, mo lo pa la mtshams bzhi’i smer babs na rtsub keg yod

¹²² тө. mi pho la srog gtso, byis pa la lus, bud med la dbang thang, rab ‘byung dang mi chen la rlung rta gtso’o

¹²³ тө. rtsi tshul la phyi nang gsang gsum las gsang b ani skyes lo’i sme bad bus bcug nas brtsi

¹²⁴ тө. spyir sme ba la lus sme ba dang, brtsi tshul la gsang ba gtso

1. “Эрэгтэй хүн мөн бөгөөс төрсөн жилийн эрхтний хүү бараас нас тоолон уруудуулан тоолох хийгээд эмэгтэй хүн мөн бөгөөс төрсөн жилийн эрхтний эх бичээс нас тоолон өгсүүлэн тоолсноор аль хүрсэн жил тэр урвасан жил мөн” гэдэг нь “phug lugs rtsis kyi legs bshad mkhas pa'i mgul rgyan beed'ur dkar po'i do shal dpyod ldan snying nor” хэмээх зурхайн сурвалж бичиг буюу сурах бичиг дэх урвасан жил олох арга мөн гэсэн байна.

2. Харин “тухайн хүн эр, эм аль болох нь хамаагүй, төрсөн жилийн эр, эмээс шалтгаалан олдог”, бас “хүний эр, эм алин болохоос шалтгаалан эрэгтэй нь төрсөн жилийн эрхтэн махбодын хүү болох эрхтэн махбодын жилээс доош уруудуулна. Эмэгтэй нь төрсөн жилийн эрхтэн махбодын эх болох эрхтэн махбод бүхий жилээс дээш өгсүүлэн насны тоогоор тоолдог” ёсыг “өөрөө урласан” хэмээгээд буруушаасан байна.

3. Лувсандагдан “төрсөн мэнгэнээс эхлээд доош нас тоолонгоор хөөгөөд тоо тэр нас хаана таарсан тэр нь буусан мэнгэ магад мөн” хэмээгээд 1897 онд төрсөн, уг номыг найруулах үед 9 настай байсан модон могой жилтэй, 4 ногоон мэнгэтэй хүний жишээгээр мэнгэ эргүүлэн тооцох аргаар тооцоход тухайн жилийн буусан мэнгэ нь 7 улаанд таарахгүй байна.

4. Харин “төвөөс огторгуй, төмөр, уул хийгээд гал, ус, шороо, мод, хийд оршино” гэх мэнгэ үсэргэн тооцох аргаар тооцоход тухайн модон могой жилтэй, 1905 онд 9 настай хүний буусан мэнгэ 7 улаан таарч байна.

Лувсандагдангийн намтар өнөө хэр тодорхойгүй байна. Одоогоор мэдэгдэж буйгаар “Богд тойн Лувсандагдан буюу бусад алдар Шанди-гийн бүрэн зохиолын гарчиг Сувдан эрих” нэрт гурван хуудас гарчигт үзвэл, түүний туурвисан нийт 89 зохиолыг нэрээр тэмдэглэсэн байна. Мөн эдгээрээс өмнө туурвисан нууцын зэрэглэлтэй нэгэн боть, мөн Лувсандагданы сонссоны тэмдэглэл Эрдэнийн эрих хэмээх өөр нэг боть тусдаа байдаг бололтой байна. Эндээс үзвэл, Лувсандагдан нь төвөд хэлээр гурван боть зохиол туурвисан гэж үзэх бүрэн үндэстэй бөгөөд түүний дотор зурхайн ухаанд холбогдох “Үхэгсдийн зурхайн товч хураангуй авахад амар Бүхнээ туслагч, хүснэгт хорлын зураг сэлт”, “Тотгорын зурхайн дөчин долоон чулууны гарын авлагын товч хураангуй Болор толь” гэх хоёр зохиол байна.

Ном зүй


Лувсандагдан (Ша мэса Содов). *sgeg rtsis rde'u zhe bdun ma'i lag len mdor bsdus zhel gyi me long zhes by aba bzhuks so//* [Тотгорын зурхай дөчин долоон чулууны гарын авлагын товч хураангуй Болор толь хэмээх оршвой. төвөд гар бичмэл]

Лувсанцүлтим (Цахар гэвш). *'byung rtsis lugs kyi lo kek brtag pa man ngag don bsdus zhes bya ba bzhuks so//* [Махбодын зурхайн ёсны жилийн тотгорыг

шинжлэх увдисын утгын хураангуй хэмээх оршвой. төвөд модон бар, 25 хуудас]

Сэрдог гэгээн. *'byung ba'i rtsi bar in chen kun bsdus zhes bya ba//* [Махбодын зурхай Эрдэнэ бүгдийн хураангуй хэмээх. богино цаастай төвөд гар бичмэл, 8 хуудас]

Даваасүрэн, Д. (2010). *Увдисын утгын хураангуй.* (Зурхай судлал III), Улаанбаатар. [Davaasuren, D. 2010. *Uvdisyn utgyn huraangui.* Ulaanbaatar] phug lugs rtses kyi legs bshad mkhas pa'i mgul rgyan beed'ur dkar po'i do shal dpyod ldan snying nor zhes by aba bzhugs so//



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.